



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2022 оны 11 сарын 02-ны
өдрийн 5988 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/64

Улаанбаатар хот

Үндсэн систем, дэмжих системийн
техникийн нөхцөл, шаардлага, заавар,
аргачлал батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн мэдээлэл солилцооны системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал”-ыг нэгдүгээр, “Танилт, нэвтрэлтийн системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал”-ыг хоёрдугаар, “Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал”-ыг гуравдугаар, “Мэдэгдэл хүргэх системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал”-ыг дөрөвдүгээр, “Албан бичиг солилцооны дундын системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал”-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, холболт үүсгэх заавар, аргачлалаар хүн, хуулийн этгээдийг хангаж ажиллахыг Үндэсний дата төв УТҮГ (М.Баттулга), И-Монгол академи УТҮГ (Л.Энхбат)-т тус тус үүрэг болгосугай.

3. Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Билэгдэмбэрэл)-т даалгасугай.

САЙД



Н.УЧРАЛ

995700

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн
1/64 тушаалын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА, ЗААВАР, АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү баримт бичгийн зорилго нь “Төрийн мэдээлэл солилцооны систем” /цаашид “ХУР” систем” гэх/-д холбогдох, мэдээлэл нийлүүлэхэд хүн, хуулийн этгээдийн сервер, сүлжээ, программ хангамжид тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, “ХУР” системд холбогдох хүн, хуулийн этгээдийг заавар, аргачлалаар хангахад оршино.

1.2. Энэхүү баримт бичгийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актад нийцүүлэв.

1.3. Энэхүү баримт бичгийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.10-д заасан журмын дагуу хүн, хуулийн этгээд /цаашид “Хэрэглэгч” гэх/-тэй байгуулсан гэрээг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөнө.

Хоёр. “ХУР” системд холбогдоход тавигдах техникийн нөхцөл, шаардлага

2.1. Хэрэглэгчийн сервер нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

- 2.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байршдаг байх;
- 2.1.2. “ХУР” системээр дамжуулан мэдээлэл солилцох зориулалттай байх;
- 2.1.3. хувийн нууцлал бүхий /VPN/ тохиргооны файлыг бусдад дамжуулахгүй байх;
- 2.1.4. албан ёсны лицензийн эрхтэй үйлдлийн системийг ашиглах;
- 2.1.5. албан ёсны лиценз бүхий вирусийн эсрэг программ хангамж ашиглан, аюулгүй байдлын шинэчлэлтийг тогтмол хийх;
- 2.1.6. хэрэглэгч өөрийн серверийн хэвийн найдвартай, тасалдалгүй, аюулгүй ажиллагааг хангах бөгөөд серверийг зориулалтын орчинд байршуулах;
- 2.1.7. сервер нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос тодорхойлсон цагийн сервертэй холбогдсон байх.

2.2. “ХУР” системд холбогдох сүлжээ нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

- 2.2.1. сүлжээний галт хана, халдлага илрүүлэх, хариу үйлдэл үзүүлэх системээр хамгаалагдсан байх;
- 2.2.2. төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй хэрэглэгч хувийн нууцлалтай сүлжээ /VPN/ ашиглаж “ХУР” системд холбогдох;
- 2.2.3. төрийн байгууллага нь төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан “ХУР” системд холбогдох.